



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 13 өдөр

Дугаар A/05

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 5.4.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аэродромын засвар арчлалтын бага оврын тоног төхөөрөмж, 2 иж бүрдэл /Алтай, Доной/” нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:

Б.Ганхуяг

Иргэний нисэхийн ерөнхий газрын Агаарын навигаци, нисэх буудлын бодлого зохицуулалтын газрын менежер /тохиролцсоноор/

Нарийн бичгийн дарга:

Ч.Чимэдноров

Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн

Гишүүд:

С.Булганцэрэн

“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын Аэродромын албаны ерөнхий инженер

Я.Гантулга

Иргэний нисэхийн залуучуудын холбооны гишүүн

М.Оргил

“Сэтгэл зүй, судалгаа мэдээллийн төв” Төрийн бус байгууллагын судлаач

2. Нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо (Б.Ганхуяг)-нд үүрэг болгосугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендер нээхэд Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үссэн тухай мэдэгдлийг гаргуулан Хуулийн хэлтэст хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ч.Чимэдноров)-д даалгасугай.

ДАРГА

П.МӨНХЖАРГАЛ



- 1721 01 0856